



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 01 сарын 20 өдөр

Дугаар A/15

Улаанбаатар хот

Салбарын удирдах ажилтны сургалт, семинар,
зөвлөгөөн зохион байгуулах тухай

“Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Төсвийн тухай хуулийн 16.5.4, 16.5.5 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын удирдах ажилтны ээлжит семинар, зөвлөгөөн, сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2. Удирдах ажилтны сургалт, семинарын хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт, семинарын зардалд зориулж 6,268,550 (зургаан сая хоёр зуун жаран найман мянга таван зуун тавь) төгрөгийг тус газрын хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч Д.Отгонбаярт зөвшөөрсүгэй.

4. Сургалт, семинарын бэлтгэл ажлыг хангаж, хөтөлбөрийн дагуу зохион байгуулахыг Дэд дарга Б.Баттулгад үүрэг болгосугай.


ДАРГА



С.ЭНХТҮВШИН

151200057

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн
А/15 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын удирдах
ажилтны 2020 оны сургалт, семинарын хөтөлбөр

Хугацаа: 2020.01.27-2020.01.30

Байршил: Улаанбаатар хот, ЦУОШГ-ын төв байрны 3 давхарын хурлын зааланд
Оролцогчид: ЦУОШГ-ын дарга, хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтэнүүд, харьяа
байгууллагын дарга, захирал, аймгийн УЦУОШТ-ийн дарга нар
Сургалт, семинарын удирдагч: ЦУОШГ-ын дарга С.Энхтүвшин

Д/д	Хугацаа	Арга хэмжээний нэр, хариуцах эзэн
1	2	3
2020 оны 01 дүгээр сарын 27. Даваа гараг		
	08.30-08.55	Оролцогчдыг бүртгэх, Ж.Энхчимэг, ЗАХ-ийн хүний нөөцийн ахлах мэргэжилтэн
Нээлтийн хэсэг		
	08.55-09.05	Сургалт, семинарын хөтөлбөр, ирцийн талаар танилцуулж, нээх, Б.Баттулга, дэд дарга
	09.05-09.40	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын 2019 оны ажлын үр дүн, 2020 оны зорилтын тухай илтгэл, С.Энхтүвшин, Газрын дарга
Газрын хэлтэсүүдийн семинар, зөвлөгөөн		
1	09.40-10.30	"2019 оны ажлын талаар цаашид анхаарах ажлууд", Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтсийн дарга Д.Уламбаяр, мэргэжилтэнүүд
	10.30-11.00	Асуулт, хариулт
2	11.00-11.20	Цайны завсарлага /Хурлын зааланд/
3	11.20-12.00	"2019 оны ажлын талаар цаашид анхаарах ажлууд", Урьдчилсан мэдээлэх хэлтийн дарга Л.Оюунжаргал, мэргэжилтнүүд
	12.00-12.30	Асуулт, хариулт
4	12.30-13.30	Үдийн цайны завсарлага
5	13.30-14.00	"2019 оны ажлын талаар цаашид анхаарах ажлууд", Санхүү, төлөвлөлт хамтын ажиллагааны хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Эрдэнэмөнх, мэргэжилтнүүд
	14.00-14.30	Асуулт, хариулт
6	14.30-15.00	"2019 оны ажлын талаар цаашид анхаарах ажлууд", Архив, мэдээллийн сангийн хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгч Ш.Хадбаатар, мэргэжилтнүүд
	15.00-15.30	Асуулт, хариулт

1	2	3
7	15.30-16.00	"2019 оны ажлын талаар цаашид анхаарах ажлууд", Орчны шинжилгээний хэлтсийн дарга Ж.Батбаяр, мэргэжилтнүүд
	16.00-16.30	Асуулт, хариулт,
8	16.30-17.00	"2019 оны ажлын талаар цаашид анхаарах ажлууд, 2019 оны УАЗ-нөөс гарсан санал, хүсэлтийн хэрэгжилт" Захиргаа, аудитын хэлтсийн дарга Н.Галцог, мэргэжилтнүүд
	17.00-17.30	Асуулт, хариулт
17.30-17.35		Тухайн өдрийн сургалт, семинарын хаалт,
2020 оны 01 дүгээр сарын 28. Мягмар гараг		
Харьяа байгууллагуудын семинар, зөвлөгөөн		
1	08.30-10.10	"2019 оны ажлын талаар цаашид анхаарах ажлууд", Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Захирал Г.Сарантуяа, Хэлтсийн дарга, хариуцсан мэргэжилтэн, инженерүүд
	10.10-10.30	Асуулт, хариулт
2	10.30-10.40	Цайны завсарлага
3	10.40-11.10	"2019 оны ажлын талаар цаашид анхаарах ажлууд", Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори, Захирал Б.Лхагвасүрэн, хариуцсан мэргэжилтэн, инженерүүд
	11.10-11.30	Асуулт, хариулт
4	11.30-12.00	"2019 оны ажлын талаар цаашид анхаарах ажлууд" Нислэгийн цаг уурын төвийн дарга Б.Баньдсүрэн, хариуцсан мэргэжилтэн, инженерүүд
	12.00-12.30	Асуулт, хариулт
5	12.30-13.30	Үдийн цайны завсарлага
2019 онд салбартаа шинжилгээний ажлаар эхний 3 байрт шалгарсан аймгийн УЦУОШТ, өртөө, харуулын тэргүүн туршлага, ажлын онцлогийн талаарх тайлан, мэдээлэл		
6	13.30-14.30	Дархан-Уул аймгийн УЦУОШТ-ийн үйл ажиллагааны товч тайлан, мэдээлэл Тэргүүний цаг уурын "Шарын гол" харуулын 2019 онд хийсэн ажлын талаар
7	14.30-15.30	Сэлэнгэ аймгийн УЦУОШТ-ийн үйл ажиллагааны товч тайлан, мэдээлэл Тэргүүний цаг уурын "Зүүнхараа" өртөөний 2019 онд хийсэн ажлын талаар
8	15.30-15.50	Цайны завсарлага
9	15.50-16.50	Ховд аймгийн УЦУОШТ-ийн үйл ажиллагааны товч тайлан, мэдээлэл Тэргүүний "Ховд" БОШ-ний лаборатори, Урьдчилан мэдээлэх хэлтсийн 2019 онд хийсэн ажлын талаар
10	16.50-17.00	Тэргүүний усны харуул Увс аймгийн " Баруунтуруун- Баруунтуруун" 2019 онд хийсэн ажлын талаар
11	17.00-17.10	Тэргүүний хур тунадас нэмэгдүүлэх экспедиц Хэнтий аймгийн "Хэрлэн бороо" экспедицийн 2019 онд хийсэн ажлын талаар
12	17.10-17.25	Асуулт хариулт
13	17.25-17.30	Тухайн өдрийн семинар, зөвлөгөөний хаалт

1	2	3
2020 оны 01 дүгээр сарын 29. Лхагва.		
Төрийн байгууллага, нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний талаар сургалт		
1	8.30-10.20	Удирдлагын академийн ХНУТэнхэмийн ахлах багш М.Мөнхбаяр
2	10.20-10.30	Цайны завсарлага
3	10.30-12.30	Удирдлагын академийн ХНУТэнхэмийн ахлах багш М.Мөнхбаяр
4	12.30-13.30	Үдийн цайны завсарлага
2019 оны ажлын үр дүн, 2020 оны зорилтын талаарх арга хэмжээ		
5	13.30-15.30	Газрын дарга, байгууллагын удирдлагуудтай уулзалт, санал, ярилцлага хийх, С.Энхтүвшин, Газрын дарга, Дэд дарга, газрын болон харъяа байгууллагын хэлтсийн дарга нар, холбогдох мэргэжилтэн, инженерүүд
6	15.30-15.40	Цайны завсарлага
7	15.40-16.00	2019 оны ажлаар шалгарсан Ус цаг уур, орчны шинжилгээний газар, нэгжид шагнал гардуулах,
8	16.00-17.30	Тухайн өдрийн сургалт, семинар, зөвлөгөөний хаалт
9	18.00	Оройн хоол
2020 оны 01 дүгээр сарын 30. Пүрэв.		
1	9.00-12.20	Агентлагийн харьяа байгууллагуудын дарга, захиралын 2019 оны үр дүнгийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулах санал ярилцах, 2020 оны үр дүнгийн болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний гэрээ байгуулах,
2	12.20-12.30	Зөвлөгөөн, сургалт, семинарын хаалт

Жич: Гүйцэтгэлийн төлөвлөгөөний сургалтанд төвийн харьяа байгууллагын нэгжийн дарга нар бүрэн оролцоно.